



СЭЛЭНГЭ АЙМАГ
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 09 өдөр

Дугаар A/93

Баруун хараа

Хараа багийн нутагт бэлчээр өнжөөх, сэлгэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар бүлгийн 52.2 дахь заалт, Баянгол сумын Хараа 1 дүгээр багийн Иргэдийн Нийтийн Хурлын 2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хараа 1 дүгээр багийн Хараа голын зүүн талын 179 дүгээр зөрлөгөөс эхлэн Найрамдалын хэсэг хүртэл, баруун талын Хар хошуунаас Ганц модны тохой хүртлэх /Жаргалантын булан, Бага өлийн ар/ талбайд дулааны улиралд бэлчээрийг өнжөөх, сэлгэн ашиглах замаар доройтлоос сэргийлэн 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл малчин болон мал бүхий өрхийг буулгахгүй байх ажлыг зохион байгуулсугай.

2. Хараа багийн нутаг дэвсгэрт бэлчээр өнжөөх, сэлгэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	М. Бямбаа	Засаг даргын орлогч
Гишүүд	Н. Давааням	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
	М. Бумцэнд	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Г. Саранцэцэг	Газрын даамал
	Л. Занданбат	Хараа 1 дүгээр багийн Засаг дарга
	Б. Түшигжаргал	Баян 2 дугаар багийн Засаг дарга
	Б. Болортuyaа	Гонир 3 дугаар багийн Засаг дарга

3. Ажлын хэсэгт даалгах нь.

а/ Хараа голын зүүн талын 179 дүгээр зөрлөгөөс эхлэн Найрамдалын хэсэг хүртэл, баруун талын Хар хошуунаас Ганц модны тохой хүртлэх /Жаргалантын булан, Бага өлийн ар/ талбайд дулааны улиралд зусдаг малчид болон мал бүхий иргэдэд зусах газрыг зааж өгөх

б/ Хараа 1 дүгээр багийн Мангирт, Цацын ар, өвөрт Сэлэнгэ аймгийн Орхон сумын малчдыг болон өөр аймаг, сумдын малчдыг зусуулахгүй байх

в/ Хараа голын зүүн талын 179 дүгээр зөрлөгөөс эхлэн Найрамдалын хэсэг хүртэл, баруун талын Хар хошуунаас Ганц модны тохой хүртлэх /Жаргалантын булан, Бага өлийн ар/ талбайд дулааны улиралд зусдаг малчид болон мал бүхий иргэдэд урьдчилан мэдэгдэх

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АРИУНБАТ